



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар A/35

Халбан

Зудын гамшигийн үед ан амьтанд  
биотехникийн арга хэмжээ авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох зудын нөлөөгөөр сумын нутаг дэвсгэрт байршиж буй зэрлэг ан амьтад идэш тэжээлгүй болох, тархац нутаг байршил нь өөрчлөгдөх зэргээр ан амьтдын жам ёс эрх алдагдаж, үхэж хорогдож болзошгүй байгаа тул ялангуяа нэн ховор, ховор амьтны байршил, популяцийн тоо толгойн судалгааг сайтар хийж, зайлшгүй шаардлагатай газар нутагт биотехникийн арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасагт үүрэг болгосугай.

2. Зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авахад шаардах өвч, тэжээл, хужир, тээвэр шатахуун, ажилласан хүмүүсийн хоол хүнсний болон ердийн хесөг ашиглах зэрэг зардал сумын төсөвт тусгагдаагүй тул Байгаль орчин аялал жуулчлалын сайдын суманд дэмжлэг үзүүлж байгаа багцаас санхүүжүүлэхийг Санхүү албаны дарга (Г.Оюунчимэг)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА // Н.АНХБАЯР